



**САЙНШАНД СУМЫН 7 ДУГААР БАГ “ГОР ГАЗ” ШТС-ЫН  
УУЛЗВАРААС БАРУУН ТИЙШ ҮРГЭЛЖЛЭХ 1.59КМ АВТО  
ЗАМЫН ГЭРЭЛТҮҮЛЭГ ХИХ АЖИЛ**

2024 оны 04 дүгээр сарын ....-ны өдөр

Сайншанд сум

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

А.Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б.Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В.Үнийн саналд зураг төсвийн үнийг 0 /Тэг/ төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г.Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 30 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “IY” 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д.Авто тээврийн зардлыг ЗТХС-ын 2022.08.22-ны өдрийн А/233 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е.ЗТХС-ын 2017 оны 212 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё.Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж.Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

З.Шугам сүлжээ, сууринуултын ажлын явцад Эрчим хүч, ус хангамжийн 2-р ангийн харьяа “Сайншанд цахилгаан шугам сүлжээний хэсэг”-ээр хяналт тавиулж холбогдох актыг бурдүүлэх.

И.Газар шорооны ажлын хийж гүйцэтгэхийн өмнө геодези хэмжилтийн эрхтэй байгууллагаар шугам трассын дагуу улаан шугам тавиулж илд далд ажлын актыг баталгаажуулсаны дараа ажлын эхлүүлэх шаардлагатай. Улаан шугам тавиулах үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байцуулна.

**1. Гадна гэрэлтүүлэг угсрах ажил**

Гэрэлтүүлгийн шонд эрчим хүчний хэмнэлттэй 120Вт-ын “LED” технологийн гэрэлтүүлэгч толгой угсрана. LED гэрэлтүүлэгч нь -40°C-ээс +65°C хэмд ажиллах боломжтой байх /IP65/. Гэрэлтүүлгийн шонгууд нь зэвэрдэггүй ган төмөр, салхины

хэт ачаалал бусад байгалийн нөлөөллийг тэсвэрлэх чадвартай болохыг баталсан баримт сертифкаттай байна. MNS 6805:2019 стандартыг хангаж ажиллах.

Гэрэлтүүлгийн шон болон самбар, бүх тусгаарлагч сууриудыг норм дүрмийн дагуу газардуулна. "/БД30-102-11"/ Гэрэлтүүлгийг ажлын зурагт заасан чиглэлийн дагуу суурилуулна. Гадна талбайн 2 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэг 53 ш, 2 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэг 5 ш-г угсрах. Авто замыг сэтлэж ухахгүйгээр хэвтээ чигт судаг өрөмдөх. Газардуулгын байгууламжийн эсэргүүцлийг хэмжижик акт үйлдэж хүлээлгэн өгнө.

## 2. Гэрэлтүүлгийн шонгийн кабель шугамын ажил

Ажил гүйцэтгэхдээ БД-43-101-03, БНБД-81-20-04, БНБД—81-30-04, БНБД-3-05-06-90г-г мөрдлөг болгоно. АВБбш 4\*25 гэрэлтүүлгийн кабелийг шуудуунд сунган 25мм<sup>2</sup> хуртэл огтлолтой кабелийн судсанд төгсгөвч шахаж кабелийн заагч тэмдэг тавих. Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дүгээр тушаалаар батлагдсан “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллах.

## 3. Гэрэлтүүлгийн самбарын тэжээлийн 0,4 кВ-ын кабелийн шугамын ажил

Ажил гүйцэтгэхдээ холбогдох норм дүрмийг мөрдлөг болгон ажиллана. АВВБ 3\*50+1\*35мм<sup>2</sup> гэрэлтүүлгийн кабелийг шуудуунд сунган 0.4кв-ын 4 судастай 50мм<sup>2</sup> огтлолтой кабелд лент хэрэглэж хуурай үзүүрлэгээ хийж кабелийн судсанд төгсгөвч шахна. Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дүгээр тушаалаар батлагдсан “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллах

### Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Талбайн угсралтын ажлыг батлагдсан төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.

4. Барилгын талбайд хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.

5. Талбайн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

6. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

8. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч тухайн ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

9. Ажил гүйцэтгэж дууссаны дараа шугамын трассын дагуу геодези хэмжилтийн байгууллагаар гүйцэтгэлийн зураг гаргуулж ГХБХБГ-ын кадастрын мэдээллийн санд бүртгүүлнэ.

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:**  
АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА

/Ч.МӨНХ-ЭРДЭНЭ/

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:**  
АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

/Н.БЯМБАЦЭЦГ/